



Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2018 оны 07 сарын 28-ний өдрийн хурлын  
05-р тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГОВЬ ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү ногдол ашгийн журам (цаашид “Журам” гэх) нь Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, олгох, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм журмын хүрээнд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

### Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- 2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- 2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- 2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 2.5. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- 2.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- 2.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

### Гурав. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ, ОЛГОХ

- 3.1. Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.



- 3.2. ТУЗ нь тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 3.3. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:
  - 3.3.1. Хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ
  - 3.3.2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
  - 3.3.3. Ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацаа
  - 3.3.4. Ногдол ашгийг олгох арга зам, хэлбэр
- 3.4. Компани хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг өөрийн байранд бэлэн мөнгөөр тараах болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх аргын алиныг ч хэрэглэж болно.
- 3.5. Хувьцаа эзэмшигч нь арилжааны банкин дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авах талаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг хувьцаа эзэмшигчийн дансанд шилжүүлж болно.

#### **Дөрөв. МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ**

- 4.1. Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.
- 4.2. Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнана.

#### **Тав. ХАРИУЦЛАГА**

- 5.1. Компани ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг бүрэн олгож дуусгана.
- 5.2. Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

